



ХААБ
ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 5 сарын 19 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.18, Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4.4, 11 дүгээр зүйлийн 11.5.15-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Малчид, бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих зорилгоор 2020 оны ноолуур бэлтгэлтэй холбоотой Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан 200420/01/121 тоот “Бодлогын гэрээ”-ний хэрэгжүүлэгч тал болох “Наранзолбоот кашмер” ХХК-ийн малчдад төлөх ноолуурын өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор биржийн арилжааны шимтгэлийн орлогоос 684,706,000.00 (зургаан зуун наян дөрвөн сая долоон зуун зургаан мянга) төгрөгийг “Наранзолбоот кашмер” ХХК-иас буцаан төвлөрүүлэх нөхцөлтэйгээр олгохыг компанийн Гүйцэтгэх захирал /Д.Дандий-Ядам/-д зөвшөөрсүгэй.

2. “Наранзолбоот кашмер” ХХК-иас авлагатай малчдын холбогдох мэдээллийг талууд баталгаажуулсны үндсэн дээр жагсаалтад заасан малчин тус бүрийн арилжааны банкин дахь дансанд “Наранзолбоот кашмер” ХХК-ийн нэрийн өмнөөс шилжүүлж, тус компанитай тооцоо нийлсэн акт үйлдэхийг компанийн Гүйцэтгэх захирал /Д.Дандий-Ядам/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын 1-д заасан 684,706,000.00 (зургаан зуун наян дөрвөн сая долоон зуун зургаан мянга) төгрөгийг 2021 оны III улиралд багтаан буцаан төвлөрүүлэх хуваарь гарган зохион байгуулж, “Наранзолбоот кашмер” ХХК-тай холбогдох гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулан, биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнахыг компанийн Гүйцэтгэх захирал /Д.Дандий-Ядам/, Ерөнхий нягтлан бодогч /Ч.Аюурзана/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ц.Болорчулуун/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц.БОЛОРЧУЛУУН

